



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.08.13 № 496

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ХЭРЛЭН СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ  
ДАРГА П.МӨНХТӨР ТАНАА

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хурлын сонгуульд оролцох Хэрлэн сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Хэрлэн сумын Монгол ардын нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Хэрлэн сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

“Хэрлэн сумын Монгол ардын нам”-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Хэрлэн сумын Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр /... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: /Аймгийн/ Сонгуулийн хороонд

Хавсралт . . . . . хуудастай.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



БОЛОРТУУЛ

011020514

Дорнод аймгийн Хэрлэн сумын Монгол  
Ардын Намын хорооны Тэргүүлэгчдийн  
2020 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн  
03-тоот тогтоолын хэвсрэлт



**ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН  
БАЙГУУЛЛАГААС 2020 ОНЫ ХЭРЛЭН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**1. ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГ, СПОРТ**

**1.1. Спорт цогцолбор, усан бассейн, хүүхдийн ордон, хүүхдийн нэгдсэн эмнэлэг, багш хөгжлийн ордныг шинээр барих ажлын хүрээнд: /МАН-ын мөрийн хөтөлбөрөөс 5.11.9-5 /**

**1.1.1. Боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч, сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулах зорилгоор судалгаа, тооцоонд үндэслэн шинээр цэцэрлэг байгуулах асуудлыг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийг дэмжих замаар шийдвэрлэнэ.**

**1.1.2. Хүүхэд хамгаалал, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайжруулж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадаад, дотоод орчинг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулах ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлнэ.**

**1.2. Өрхийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллана.**

**1.3. Хүүхдийн шүд цоорох өвчлөлийг бууруулах, эмчлэн эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх ажиллагааг үргэлжлүүлж,**

боловсролын болон бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.

1.4. “Сургууль, цэцэрлэгийн бүс” төслийг үргэлжлүүлэн сургууль, цэцэрлэгийн гаднах орчинд хүүхдэд ээлтэй, ногоон байгууламж бүхий эко орчин бүрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.5. Хүүхэд залуусын бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа спортын клубүүдийн үйл ажиллагааг дэмжинэ.

1.6. Хотын төв болон гэр хороололд стандартын шаардлага хангасан тоглоом, чийрэгжүүлэлтийн талбайнуудыг шинээр байгуулж хүрэлцээг нэмэгдүүлнэ.

## 2. ДЭД БҮТЭЦ, ЗАМ ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

2.1. Чойбалсангийн ДЦС-ын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөнө. /МАН-ын мөрийн хөтөлбөрийн 5.11.9-2 /

2.1.1. Чойбалсан хотын гэр хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах, өргөтгөх, нэмэлт цахилгаан дамжуулах шугам барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.


2.2 Чойбалсан нисэх буудлыг олон улсын 4С зэрэглэл бүхий зорчигч үйлчилгээний цогцолбор болгоно: /МАН-ын мөрийн хөтөлбөрөөс 5.11.9-3 /

2.3. Чойбалсан хот доторх авто замын сүлжээг өргөтгөн шинэчилнэ. /МАН-ын мөрийн хөтөлбөрөөс 5.11.9-8 /

2.3.1. Чойбалсан хот доторх нийтийн эзэмшлийн гудамж талбайд явган хүний болон дугуйн замыг нэмэгдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй байдлаар сайжруулна.

2.4. Чойбалсан хотын цэвэр, бохир усны болон дулааны шугам сүлжээг өргөтгөн шинэчилнэ:/МАН-ын мөрийн хөтөлбөрөөс 5.11.9-6/

2.4.1. Чойбалсан хотын ундны усны эх үүсвэрийн цуглуулах шугам, Хэрлэн сумын гэр хороололд зөөврийн усан сан, гүний худгийг нэмэгдүүлнэ.



2.4.2. Хэрлэн сумын гэр хороололд халуун усны газрын хүрэлцээг нэмэгдүүлж, нийтийн эзэмшлийн газарт нийтийн бие засах газар байгуулах, иргэдийн эрүүл, цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.5. Монгол дайчдын хөшөө, Бунхан толгой дахь нисгэгчдийн хөшөө, Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнг үйл ажиллагааг, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоотойгоор хамтран тохижуулна.

### 3. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН

3.1. Хотын иргэдийг мах, сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах зорилгоор эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлэх бодлого баримтална.

3.2. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлж, өрхийн аж ахуйг дэмжин ажиллана.

3.3. Малын гаралтай түүхий эд боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг байгуулах, шинэ техник, технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана.

3.4. Чойбалсан хот дахь мал нядалгааны цэгүүдийг стандартын шаардлагад нийцүүлэх, орчны эрүүл ахуйн шаардлагыг хангах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

### 4. НИЙГМИЙН ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

4.1. Орон нутгийн мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв, политехник коллежид мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх, төгсөгчдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлнэ.

4.2. Өрх бүр угийн бичгээ хөтөлж, удмын түүх, ургийн хэлхээгээ мэддэг үндэсний уламжлалыг шинэ гэр бүл бүрд өвлүүлэх ажлыг зохион байгуулна.

4.3. Чойбалсан хотод нийтийн тээврийн унаагаар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.4. “Ахмадын ачлал” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, аймаг, сумын Ахмадын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана.

4.5. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээнд холбогдсон амины орон сууцны хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

## 5. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН БАЙГУУЛАМЖ

5.1. Хог хаягдал боловсруулах үйлдвэр барина. /МАН-ын мөрийн хөтөлбөрөөс 5.11.9-7/

5.1.1. Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах үйл ажиллагаа явуулж байгаа иргэн аж ахуйн нэгжийг дэмжинэ.


5.1.2 Чойбалсан хотын хог хаягдлын төвлөрсөн цэгийг нүүлгэн шилжүүлж, нөхөн сэргээлт хийнэ.

5.1.3 Чойбалсан хотын тохижилт, хог хаягдлын асуудлыг боловсронгуй болгох зорилгоор хэрэгжиж буй “Цэмцгэр Чойбалсан” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

5.2. Олон төрлийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, инженерийн хангамжтай орон сууцаар хангана:/МАН-ын мөрийн хөтөлбөрөөс 5.11.9-1 /

5.2.1 Чойбалсан хотын гэр хороолол болон зарим газруудад дахин төлөвлөлт хийж, орон сууцжуулах ажлыг эхлүүлнэ.

5.2.2 Чойбалсан хотын орон сууцны төлөвлөлтөд оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нийгмийн дэд бүтэц, ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай бүхий тохилог орчин бүрдүүлэх стандарт хэрэгжүүлж, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.



Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан дүгнэлт гаргахтай холбогдуулан улс төрийн нам, эвслээс мөрийн хөтөлбөрийн хавсралтаар ирүүлэх мэдээлэл.

№	Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ	Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн тооцооллыг хийхдээ төсвийн төсөөллийг баримталсан эсэх (тийм, үгүй)	Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн аль заалтад хамаарч буй (тийм, үгүй)	УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050”-н аль заалтад хамаарч буй (заалтыг бичих)	Тайлбар
	1	2	3	4	5
1.ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГ, СПОРТ					
1	Боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч, сургуулийн өмнөх насны хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулах зорилгоор судалгаа, тооцоонд үндэслэн шинээр цэцэрлэг байгуулах асуудлыг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийг дэмжих замаар шийдвэрлэнэ.	тийм	тийм	Хоёр. Хүний хөгжил Боловсрол Зорилт 2.1.15	
2	Хүүхэд хамгаалал, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайжруулж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадаад, дотоод орчинг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулах ажлыг шат дараагайгаар хэрэгжүүлнэ.	тийм	тийм	Хоёр. Хүний хөгжил Боловсрол Зорилт 2.1.15	
3	Өрхийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллана.	тийм	тийм	Хоёр. Хүний хөгжил. Эрүүл мэнд Зорилт 2.2.10	
	Хүүхдийн шүд цоорох өвчлөлийг				

4	бууруулах, эмчлэн эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх ажиллагааг үргэлжлүүлж, боловсролын болон бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ.	тийм	тийм	Хоёр. Хүний хөгжил. Эрүүл мэнд Зорилт 2.2.1
5	Сургууль, цэцэрлэгийн бүс" төслийг үргэлжлүүлэн сургууль, цэцэрлэгийн гаднах орчинд хүүхдэд ээлтэй, ногоон байгууламж бүхий эко орчин бүрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	тийм	тийм	Хоёр. Хүний хөгжил. Хүнд ээлтэй амьдрах орчин Зорилт 2.5.5
6	Хүүхэд залуусын бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа спортын клубүүдийн үйл ажиллагааг дэмжинэ.	тийм	тийм	Хоёр. Хүний хөгжил Эрүүл мэнд Зорилт 2.2.27
7	Хотын төв болон гэр хороололд стандартын шаардлага хангасан тоглоом, чийрэгжүүлэлтийн талбайнуудыг шинээр байгуулж хүрэлцээг нэмэгдүүлнэ.	тийм	тийм	Гурав. Амьдралын чанар ба дундаж давхарга. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг Зорилт 3.5.5
<b>2. ДЭД БҮТЭЦ, ЗАМ ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ</b>				
1	Чойбалсан хотын гэр хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах, өргөтгөх, нэмэлт цахилгаан дамжуулах шугам барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	тийм	тийм	Найм. Бүсчилсэн хөгжил. Дорнод Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, үйлдвэрлэл, аялал, жуулчлал, ногоон хөгжлийн бүс Зорилт 8.1.12
2	Чойбалсан хот доторх нийтийн эзэмшлийн гудамж талбайд явган хүний болон дугуйн замыг нэмэгдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй	тийм	тийм	Найм. Бүсчилсэн хөгжил. Дорнод Монголын эдийн засгийн

	иргэдэд ээлтэй байдлаар сайжруулна.			хөгжлийн тэнхлэг, үйлдвэрлэл, аялал, жуулчлал, ногоон хөгжлийн бүс Зорилт 8.1.12	
3	Чойбалсан хотын ундны усны эх үүсвэрийн цуглуулах шугам, Хэрлэн сумын гэр хороололд зөөврийн усан сан, гүний худгийг нэмэгдүүлнэ.	тийм	тийм	Зургаа. Ногоон хөгжил Үнэт баялаг ус Зорилт 6.3.13	
4	Хэрлэн сумын гэр хороололд халуун усны газрын хүрэлцээг нэмэгдүүлж, нийтийн эзэмшлийн газарт нийтийн бие засах газар байгуулах, иргэдийн эрүүл, цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	тийм	тийм	Зургаа. Ногоон хөгжил Хүлэмжийн хийн ялгарал багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил Зорилт 6.4.22	
5	Монгол дайчдын хөшөө, Бунхан толгой дахь нисгэгчдийн хөшөө, Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнг үйл ажиллагааг, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоотойгоор хамтран тохижуулна.	тийм	тийм	Найм. Бүсчилсэн хөгжил Дорнод Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, үйлдвэрлэл, аялал, жуулчлал, ногоон хөгжлийн бүс Зорилт 8.1.9	
3. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН					
1	Хотын иргэдийг мах, сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах зорилгоор эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлэх бодлого баримтална.	тийм	тийм	Найм. Бүсчилсэн хөгжил Дорнод Монголын эдийн засгийн хөгжлийн тэнхлэг, үйлдвэрлэл, аялал, жуулчлал, ногоон хөгжлийн бүс Зорилт 8.1.3	



2	Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлж, өрхийн аж ахуйг дэмжин ажиллана.	тийм	тийм	тийм	Гурав. Амьдралын чанар ба дундаж давхарга, Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес Зорилт 3.3.7	
3	Малын гаралтай түүхий эд боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг байгуулах, шинэ техник, технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана.	тийм		тийм	Гурав. Амьдралын чанар ба дундаж давхарга, Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес Зорилт 3.3.3 Зорилт 3.3.7	
4	Чойбалсан хот дахь мал нядалгааны цэгүүдийг стандартын шаардлагад нийцүүлэх, орчны эрүүл ахуйн шаардлагыг хангах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.	тийм		тийм	Гурав. Амьдралын чанар ба дундаж давхарга, Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес Зорилт 3.3.7	
<b>4. НИЙГМИЙН ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ</b>						
1	Орон нутгийн мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв, политехник коллежид мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх, төгсөгчдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлнэ.	тийм		тийм	Хоёр. Хүний хөгжил Боловсрол Зорилт 2.1.27	
2	Өрх бүр угийн бичгээ хөтөлж, удмын түүх, ургийн хэлхээгээ мэддэг үндэсний уламжлалыг шинэ гэр бүл бүрд өвлүүлэх ажлыг зохион байгуулна.	тийм		тийм	Хоёр. Хүний хөгжил Монгол хүний удмын сан Зорилт 2.7.1	
3	Чойбалсан хотод нийтийн тээврийн унаагаар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	тийм		тийм	Гурав. Амьдралын чанар ба дундаж давхарга, Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны	

					шинэчлэл
					Зорилт 3.1.16, 3.1.17
4	“Ахмадын ачлал” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, аймаг, сумын Ахмадын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана.	тийм	тийм		Гурав. Амьдралын чанар ба дундаж давхарга, Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл  Зорилт 3.1.16,
5	Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээнд холбогдсон амины орон сууцны хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	тийм	тийм		Хоёр. Хүний хөгжил Хүнд ээлтэй амьдрах орчин Зорилт 2.5.3
<b>5. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН БАЙГУУЛАМЖ</b>					
1	Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах үйл ажиллагаа явуулж байгаа иргэн аж ахуйн нэгжийг дэмжинэ.	тийм	тийм		Зургаа. Ногоон хөгжил Хүлэмжийн хийн ялгарал багаатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил Зорилт 6.4.3
2	Чойбалсан хотын хог хаягдлын төвлөрсөн цэгийг нүүлгэн шилжүүлж, нөхөн сэргээлт хийнэ.	тийм	тийм		Зургаа. Ногоон хөгжил Хүлэмжийн хийн ялгарал багаатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил Зорилт 6.4.8
					Зургаа. Ногоон хөгжил

3	Чойбалсан хотын тохижилт, хог хаягдлын асуудлыг боловсронгуй болгох зорилгоор хэрэгжиж буй “Цэмцгэр Чойбалсан” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	тийм	тийм	Хүлэмжийн хийн ялгарал багаай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил Зорилт 6.4.4
4	Чойбалсан хотын гэр хороолол болон зарим газруудад дахин төлөвлөлт хийж, орон сууцжуулах ажлыг эхлүүлнэ.	тийм	тийм	Гурав. Амьдралын чанар ба дундаж давхарга, Орлогод нийцсэн орон байр Зорилт 3.2.3, 3.2.5
5	Чойбалсан хотын орон сууцны төлөвлөлтөд оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх нийгмийн дэд бүтэц, ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай бүхий тохилог орчин бүрдүүлэх стандарт хэрэгжүүлж, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.	тийм	тийм	Гурав. Амьдралын чанар ба дундаж давхарга, Орлогод нийцсэн орон байр Зорилт 3.2.8

Хөтөлбөрийг бэлтгэсэн:

Дорнод аймгийн Хэрлэн сумын Монгол Ардын намын хороо-г төлөөлж

Дэд дарга

О.Пүрэв-Очир

2020 оны 07 дугаар сарын 19-ны өдөр.

Дорнод аймгийн Хэрлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт санхүүгийн тодорхой эх үүсвэр, шаардлагагай зорилт, арга хэмжээний жагсаалт

/сая төгрөгөөр/

№	Шаардлагах зарчмын нийт дүн (сая төгрөг)	Мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагах санхүүгийн эх үүсвэр болон зарчмын дүн (он тус бүрээр/2021												Тайлбар												
		2021						2023							2024											
		3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14		15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26
		Урьдчилсан төсөв	Талааны зардал	Талаа, дотоодын хөрөнгө оруулалт	37-н гаваад дотоод үндэс цаас	Концессын гэрээ	Бусад эх үүсвэр тусламж	Урьдчилсан төсөв	Талааны зардал	Талаа, дотоодын хөрөнгө оруулалт	37-н гаваад дотоод үндэс цаас	Концессын гэрээ	Бусад эх үүсвэр тусламж	Урьдчилсан төсөв	Талааны зардал	Талаа, дотоодын хөрөнгө оруулалт	37-н гаваад дотоод үндэс цаас	Концессын гэрээ	Бусад эх үүсвэр тусламж	Урьдчилсан төсөв	Талааны зардал	Талаа, дотоодын хөрөнгө оруулалт	37-н гаваад дотоод үндэс цаас	Концессын гэрээ	Бусад эх үүсвэр тусламж	
		30						30												30						
		40						40												60						
		200						200												30						
1	Хүүхдийн шүд цоорох өвчлөлийг бууруулах, эмчлэн эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх ажиллагааг үргэлжлүүлж, боловсролын болон бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлнэ	120																								
2	“Сургууль, цэцэрлэгийн бүс” төслийг үргэлжлүүлэн сургууль, цэцэрлэгийн гаднах орчинд хүүхдэд ээлтэй, ногоон байгууламж бүхий эко орчин бүрдүүлэх ажлын үе шаттай хэрэгжүүлнэ.																									
3	Хотын төв болон гэр хороололд стандартын шаардлага хангасан																									

1.ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГ, СПОРТ


Жил бүр 2-с

Жил бүр 1-2 бүсэд төсөл хэрэгжүүлнэ.

Дээрхи үр дүнд Чойбалсан хотын нийт өсвөр насны хүүхдүүдийн шүдийг 100 хувь эрүүлжүүлнэ.

тоглоом, чирэгжүүлэлтийн талбайнуудыг шинээр байгуулж хүрэлцээг нэмэгдүүлнэ.	320	80																	80	80	багагүй цэгт шинээр байгуулна.	
<b>2. ДЭД БҮТЭЦ, ЗАМ ТЭЭВЭР, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ</b>																						
1	Чойбалсан хот доторх нийтийн эзэмшлийн туламж талбайд явган хүний болон дугуйн замыг нэмэгдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй байдлаар сайжруулна.	330	65																	82.5	100	Нийт 6500 м2 талбайд тохижилт хийнэ.
2	Чойбалсан хотын ундны усны эх үүсвэрийн цуглуулах шугам, Хэрлэн сумын гэр хороололд зооврийн усан сан, гүний хулгийг нэмэгдүүлнэ.	400	100																	100		Тухайн жилд 2-с багагүй нийтийн орон сууцанд шинэчлэлт хийнэ.
3	Хэрлэн сумын гэр хороололд халуун усны газрын хүрэлцэн нэмэгдүүлж, нийтийн эзэмшлийн газарт нийтийн бие засах газар байгуулах, иргэдийн эрүүл, цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	270	130																	70		Сумын хэмжээнд шаардлагай 4 цэгт шинээр байгуулна.
4	Монгол дайчдын хөшөө, Бунхан толгой дахь нисгэгчдийн хөшөө, Бурхан батшийн цогцолт хүрээлэнг үйл ажиллагааг, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоотойгоор хамтран тохижуулна.	600																			200	Галаад дотоодын хөрөнгө оруулагчдыг дэмжин ажиллана.
<b>3. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН</b>																						
1	Малын гаралтай түүхий эд боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг байгуулах, шинэ техник, технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана.	200	50																		50	Газар зохион байгуулалт, дэд бүтцийг шийдвэрлэх зарчмаар дэмжин ажиллана.
<b>4. НИЙГЭМИЙН ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ</b>																						

1	Чойбалсан хотод нийтийн тээврийн унаагаар ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	170	15															30						110	Төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулан хамтран ажиллана.	
2	Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сулжээнд холбогдсон амины орон сууцны хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	750	200																150						250	Хэрлэн сумын 11-н багт тэгш хүртээмжтэй байлаар шийдвэрлэнэ.
<b>5. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН БАЙГУУЛАМЖ</b>																										
1	Чойбалсан хотын хот хаягдлын төвлөрсөн цэгийг нүүлгэн шилжүүлж, нохон сэргээлт хийнэ.	1200	600																						600	Гадаадын зээл болон ОНТөсөв хөрөнгөөр гүйцэтгэнэ.
2	Чойбалсан хотын тохирялт, хот хаягдлын асуудлыг боловсронгуй болгох зорилгоор хэрэгжиж буй "Цэмигэр Чойбалсан" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	180	45																45						45	Тухайн жилд төлөвлөгдсөн цогцуудад хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэнэ.
3	Чойбалсан хотын гэр хороолол болон зарим газруудад дахин төлөвлөлт хийж, орон сууцжуулах ажлыг эхлүүлнэ.	630	220																110						190	Дахин төлөвлөлтийн ТЭЗҮ, зураг төсөв хийх.
		<b>5,370</b>	<b>975</b>						<b>772.5</b>										<b>807.5</b>						<b>1615</b>	
<b>Дүн</b>																										


  
**Хөтөлбөрийг бэлтгэсэн: Хэрлэн сумын Мөнгөл-Арлын намын хороог төлөөлж.**  
 Дэд дарга **О. Пүрэв-Очир**  
 2020 оны 07 дугаар сарын 19-ны өдөр